

Эрдэнэ зуу хийдийн түүх буюу төр, шашныг
хослон барих зарчим

Удо Б. Баркманн*

Монголчуудын төр, шашны уламжлалыг Хархорум шиг өнгөрсөн үеийнхээ амьд түүхээр бүрэн төгс илтгэн харуулсан газар Монголд бараг байхгүй буй заа. Ийн бодохуйд Хубилай хаан, Пагва лам Лодойжалцан нарын үндэслэсэн төр, шашныг хослон хөгжүүлэх зарчим өөрийн эрхгүй санаанд орно. Энэ газар нэгэн үе Монголын Их эзэнт гүрний нийслэл, тэгэхдээ бүр янз бүрийн шашны төлөөлөгчид хоорондоо чөлөөтэй ном хаялцан мэтгэлцдэг хот байжээ. Хархорумд үйл ажиллагаа явуулж байсан бусад шашинтай харьцуулахад Буддын шашин илүү зонхилох үүрэг гүйцэтгэж байсныг археологийн олдворууд¹ харуулдаг. Хожим энд Эрдэнэ зуу хийд байгуулагдан Монголын шарын шашны нэг гол төв болон хөгжжээ.

Монголын түүхийн бичлэгт Хархорумын түүхэн хувьсал өөрчлөлтийг нэг талаас нийслэл хот байсан, нөгөө талаас алдарт Эрдэнэ зуу хийдийн үүсэл хөгжил түүхийг нь тодорхойлж байсан гэсэн үе шаттайгаар авч үзэж хэвшжээ. Тэгэхдээ Чингисийн алтан ургийнхны хувьд ямар ч цаг үед өнгөрсөн үеийнх нь ноёрхол, хэзээ ч орхиогүй эрх мэдлээ тогтоох эрмэлзлийнх нь бэлгэ тэмдэг, үүгээрээ энэ хоёр үе шатны хоорондох гүүр болж байсан тэр газрын бэлгэдлийн их утга учрыг анзааралгүй өнгөрөх нь олонтаа.

Энэхүү өгүүллээрээ ашиглах боломжтой, мөн заримыг нь шинээр олж авсан сурвалжийн тусламжтайгаар Эрдэнэ зуу хийдийн түүхийг дүрслэн үзүүлж, уг түүхийг Чингисийн алтан ургийнхны эрх мэдлээ тогтоох байнгын эрмэлзэл хэрхэн тодорхойлж байсны цаад учир шалтгааныг олж харуулахыг зорив. Хэдийгээр судлах зүйл маань түүхийн илүү өргөн цар хүрээтэй үйл явц, тухайлбал халх монголчуудын дунд шарын шашныг дэлгэрүүлсэн үйл явцад хамаарах ч, гол асуудалдаа анхаарлаа төвлөрүүлэхийн тулд тэрхүү үйл явцын цаад өргөн учир холбогдлыг нарийвчлан тодорхой авч үзсэнгүй. Хачирхалтай нь Монгол сурвалжуудад Хархорумыг бараг дурдаагүй байдаг. Гагцхүү Саган сэцэн “Хоромхон нэрт

* Монгол Улсын Их Сургууль, *Монгол Судлалын Төв*

¹ Д. Баяр, Хар хорум хотоос илэрсэн Их Монгол улсын бурханы шашны холбогдолт олдвор, *Чингис хаан ба Монгол бурханы шашин*, Улаанбаатар 2006, 23-31 дэх тал.

балгасаныг барих болов. Хуух алаг шарыг цохих болов?"² хэмээн 1415 онд зарим ойрад санаа бодлоо илэрхийлж байсан тухай тэмдэглэсэн байна. Ийнхүү тэд эрх мэдлээ тогтооно гэж урьдаас бодож төлөвлөж байсан ажээ. Ойрадууд эрх мэдлийн төлөөх цус урсгасан тулаануудад халхчуудыг давамгайлж байсан бөгөөд Хоромхон (Хархорум)-ыг Ойрадын хааны орд өргөө болгоно гэдэг нь Халхын ноёд язгууртнуудын доторх омог бардам Чингисийн алтан ургийнхны хувьд басамжлан доромжлуулснаас ялгаагүй хэрэг байсан ажээ.

Хархорумын талаарх дараачийн мэдээлэл нь Батмөнх даян хааны отгон хөвгүүн Гэрсэнзийн ач Чингисийн алтан ургийн Абатай сайн хан (1554-1588)-ы үйл ажиллагаатай холбоотой. Тэр бээр модон бар жил (1554) Сэлэнгэ мөрний сав газар төржээ. Эхээс төрсөн байдал нь Чингис хааныг санагдуулдаг. Чингис "баруун гартаа шагайн чинээ нөжин атган төрсөн"³ бол Абатайг "хөмхөй хуруу нь хар цустай төрсөн" гэдэг.⁴ Илэрхий ижил төстэй энэ хоёр тохиолдол эртний буддын ном судруудад ч гардаг хувь тавилангийн бэлгэ тэмдэг байсан мэт санагдана.

Зөн бэлгэдлийн шинжтэй үйл явдлууд болж, мөн 1581 онд монгол Түмэд (Халхад шашин дэлгэрүүлэх газрыг судалж мэдэх зорилготой байсан бололтой)-ийн худалдаачдыг дагалдан ирсэн нэгэн ламын нөлөөгөөр тэрхүү Абатай шарын шашныг сонирхож эхэлжээ. Ингээд тэр лам залж ирүүлэхийг хүсэж байгаагаар Түмэдийн Алтан хаан (1507-1582)-д уламжилжээ.

Хөх хогод төвлөн сууж байсан Алтан хаан шарын шашинд ороод хэдэн жил болсон байв. Тэр бээр 1577 онд Төвдийн буддын шашны *гэлүгба* (dGe-lugs-pa)-гийн ёсны тэргүүн Содномжамцтай (1543-1588) Хөх нуурын ойролцоо уулзаж, түүнд Далай лам цол хайрлажээ. Харин Содномжамц Алтан хаанд Чакраварти сэцэн хаан цолыг соёрхсон байна. Содномжамц үүгээрээ Алтан хааныг "онцлон дэлхийн жинхэнэ эзэн Чакравартийн Хубилай сэцэнтэй эн тэнцүү тавьсан"⁵ тул тийнхүү харилцан бие биедээ цол шагнасан нь бэлгэдлийн гүн утга учиртай байлаа. Хубилай хаан, Пагва лам Лодойжалцан нарын байгуулсан хэлэлцээр, тэдний үндэслэсэн төр, шашныг хослон барих зарчим хоёрын ижил төстэй болохыг анзаарахгүй байхын аргагүй байв.

Лам залах Абатайн хүсэлтийг Алтан хаан дуртай хүлээж авсан нь мэдээж. Далай лам Содномжамцын даалгавраар монголчуудын дунд шашин дэлгэрүүлэх ажлыг удирдаж байсан Алтан хааны шашны зөвлөх лам *Донгор* (Ston 'khor) манзушир (мөн манзушир хутагт нэрээрээ алдаршсан) ноёрхогч байр сууринд буй Чингисийн алтан ургийнхны хэн нэгний тусламжтайгаар Халх Монголд шашнаа дэлгэрүүлэх ажлыг хэрэгжүүлэх цорын ганц боломж олдож буйг ухаарчээ. Алтан хаан нас барахынхаа өмнөхөн Абатай руу *Гоман пансу* (Sgomang pangso) хэмээх ламыг илгээх шийдвэрийг гаргасан байна. Хожим 1583 онд

² Саган сэцэн, *Эрдэнийн товч*, = Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал 8, Улаанбаатар 2006, 107 дахь тал.

³ *Монголын нууц товчоон*, = Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал 1, Улаанбаатар 2006, 27 дахь тал.

⁴ H. R. Kämpfe, *Das Asaragči neretü-yin teike des Byamba erke daičing alias Šamba jasaγ* (Eine mongolische Chronik des 17. Jahrhunderts), = Asiatische Forschungen, Bd. 81, Wiesbaden 1983, 120 дахь тал.; Цамба, *Асрагч нэртнийн түүх*, Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал 9, Улаанбаатар 2006, 71 дэх тал.

⁵ K. Sagaster, *Der mongolische Buddhismus: Geschichte*, in *Dschingis Khan und seine Erben*, München 2005, 344 дэх тал.

Самала нансу (Samala nangso) хэмээх лам (Semele ч гэдэг) араас нь иржээ.⁶ Түүнээс хойш тэр хоёр лам Абатайд шарын шашныг дэлгэрүүлэх асуудлаар зөвлөлгөө өгдөг болов. Тэд бас Халх Монголд шарын шашны анхны ариун шүтээн босгохыг Абатайгаас шавдуулж байсан гэж үзэж болно.

Тийнхүү Абатай Эрдэнэ зуу хийдийг үүсгэн байгуулжээ. Уг хийдийг барьсан түүхийн эхний үе шатыг нарийвчлан тодорхойлох аргагүй байдаг. Уг үйл явдалд газар зүй, цаг хугацааны хувьд маш ойр он дарааллын бичиг болох *Асрагч нэртийн түүхэнд*: “Модон тахиа жилийн зун (1585) Шанхатын ар дахь хуучин балгасанд яндар дэлдэж, тэр жилд сүмийн үйл үйлдвэй”⁷ хэмээжээ. Түүхч Галдангийн *Эрдэнийн эрхи*, тэрчлэн “*Эрдэнэ зуугийн түүх*”⁸ зэрэг бусад сурвалж бичигт өгүүлснээр бол “Чингис хааны гутгаар хөвгүүн Өгөөдэй хаан”, хожим мөн “Тогоон төмөр хаан”-ы төвлөн сууж байсан гэгддэг (тэгэхлээр Хархорум)⁹ Шар азарга уулын ар дахь хуучин *Тахай нэрт балгасны* газрын хавьцаанд Абатай нэгэн байшинг ашиглуулж (эсвэл бариулж?) байжээ.

Тахай балгас хэмээх нэр анхаарал татаж байна. Пэрлээ¹⁰ *Тахай балгасыг Монголын нууц товчоон*-д ч нэр дурдагддаг¹¹, хожим Хархорумыг үүсгэн байгуулсан газар болох *Тайхал шивээ* хэмээх эртний бэхлэлт суурин мөн хэмээн үзсэн. Харин “тахилга” гэсэн утгатай *тахих*, *тайх* хэмээх үйл үгнээс гаралтай байж болох *тахай* хэмээх үгийн утгыг ч бас бодож үзүүштэй байгаа юм. Монгол судлаачид түүнийг эрт дээр цагт тэнд өвөг дээдсийн тахилын сүм байсныг заасан нэр байж болох юм хэмээн үзэж буй. Тэр ч байтугай Бира¹² энэ сүмийг бүр Уйгур улсын үед байсан бололтой гэжээ. Сүм байгуулж байсан газартай тийнхүү холбон авч үзсэн нь сонирхол ихээхэн татаж, зарим асуудлыг дэвшүүлэн тавьж байна. Юуны өмнө Монголын эзэнт гүрний эртний нийслэлийн туурийн хажууд буй энэ газарт Абатай байнга орд өргөөгөө барьж суудаг байсан гэж үзэж болох юм. Батмөнх даян хааны удмаас гаралтай, ноёрхогч байр сууринд буй Чингисийн алтан ургийн Абатай мэтийн хүнд энэ газар асар их бэлгэдлийн утга учиртай байсан зэрэг нь үүнийг гэрчилж байна. Бие хүнийхээ хувьд ч, тэр газрын нөлөө ач холбогдол нь ч Абатай тэнд ямар нэг хэлбэрээр өвөг дээдсээ хүндэтгэх ёслол үйлддэг байсан болов уу хэмээн таамаглахад хүргэж байна. Мөн эртнээс энэ газарт байсан, магад ч үгүй өвөг дээдсээ тахин шүтэхэд байнга ашигладаг байсан байшинд тэр өвөг дээдсийнхээ тахилгын ёслолыг үйлддэг байсан байж болох юм.

⁶ Über die Entsendung beider Lamas siehe H. R. Kämpfe, *Das Asaragči neretü-yin teüke des Byamba erke daičing alias Šamba jasay* (Eine mongolische Chronik des 17. Jahrhunderts), =Asiatische Forschungen, Bd. 81, Wiesbaden 1983, 121 дахь тал.

⁷ Мөн тэнд, 121 дэх тал; Жамба, *Асрагч нэртийн түүх*, Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал 9, Улаанбаатар 2006, 72 дахь тал.

⁸ *История Эрдэни-Дзу*, Перевод с монгольского, введение, комментарии и приложения А. Д. Цэндиной, – Памятники письменности Востока СХVIII, Москва 1999.

⁹ Галдан, *Эрдэнийн эрхи*, = Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал, Улаанбаатар 2006, 183 дахь тал; *История Эрдэни-Дзу*, Перевод с монгольского, введение, комментарии и приложения А. Д. Цэндиной, = Памятники письменности Востока СХVIII, Москва 1999, 66 дахь тал; *Эрдэнэ зуу хийдийн түүх*, Улаанбаатар 1996, 7 дахь тал.

¹⁰ Х. Пэрлээ, *Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон*, Улаанбаатар 1961, 76 дахь тал.

¹¹ “Мэргидийн зарим улс дайжиж Тайхалд хорго барьж хороолжухуй.” гэж Монголын нууц товчоонд бичсэн. *Монголын нууц товчоон*, = Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал 1, Улаанбаатар 2006, 145 дахь тал.

¹² Ш. Бира, *О золотой книге Ш. Дамдина*, Улаанбаатар 1964, 45 дахь тал.

Одоо тухайн цаг үед болж байсан үйл явдлуудад анхаарлаа түр хандуулья. Уг үйл явдлыг тун ойроос дүрсэлсэн *Асрагч нэртийн түүх* он дарааллын бичигт тэмдэглэснээс үзвэл Абатай 1586¹³ оны зуны адаг сарын 15-нд Хөх хотод Далай лам Содномжамцтай уулзсан байна.¹⁴ Энэ уулзалт хоёуланд нь ач холбогдолтой байсан нь лав. Гэхдээ 1582 онд Алтан хааныг нас барсны дараа монголчуудын дунд шашнаа дэлгэрүүлэх бодлогоо хэрэгжүүлэхэд Чингисийн алтан ургийн өндөр эрх дархтай хүнийг дахин татан оролцуулж чадаагүй байсан Далай ламд бүр ч чухал байжээ. Монголчуудын хувьд бэлгэдлийн их утга учиртай Тахай балгас (Хархорум)-наа төвлөн суудаг, өндөр дээд язгууртай Чингисийн алтан ургийн Абатай үүнд нь яг таарах хүн шиг санагджээ. Тиймээс уулзалтаар санамсаргүй явдалд найдахгүй амар болжээ. Далай лам уулзалтад чамбай бэлтгэж, Абатайн орд өргөөнд сууж буй өөрийн итгэлт хүмүүс болох лам *Гоман нансу* (Sgomang nangso), *Самала нансу* (Samala nangso) нараас Абатай, түүний улс төрийн үзэл, шашин шүтлэг, өвөг дээдсээ тахиж ёс. Тахай балгасан дахь орд өргөөнийх нь талаарх мэдээллийг авч байв. Гэхдээ Абатай ч бас тодорхой төлөвлөгөөтэй байлаа. Тэр Далай ламтай эвсэн, аугаа их өвөг дээдсийнхээ сажийн ёсны хуучин зөвлөхүүдийн үзүүлж байсан их нөлөөг бодолцон, ядаж л улс төрийн нэр нөлөөгөө дээшлүүлэх эрмэлзэлтэй байв. Зорилгоо ийн төсөөлсөн Абатай Далай ламын халх монголчуудын дунд шашнаа дэлгэрүүлэх бодлогыг дэмжихэд бэлэн байв.

Далай лам Абатайтай Хөх хотод уулзахдаа ихээхэн хүндэтгэл үзүүлж, бэлэг сэлт барьжээ. Тэр түүнд *Хэ-очир* (Keivčir)–ын авшгийг хүртэж, түүнийг монголчуудыг даасан бурхан Очирваанийн (санскритаар *Vajrapāni*) хувилгаанаар өргөмжилж, Номын их очир хаан цолоор шагнажээ. Тэрбээр энэ ёслолыг үйлдэхдээ шарын шашинтнууд Чингис хааныг Очирваанийн хувилгаан хэмээн үздэгийг бас Абатайд хэлэхээ мартаагүй нь лав. Абатай Содномжамцаас янз бүрийн бурхан шүтээний зүйлсээс гадна барын арьсан гэр бэлгэнд авчээ. Ийнхүү ихээхэн хүндэтгэл үзүүлснийхээ дараа Далай лам хүсэлтээ уламжлан, Халх Монголд сүм хийд байгуулах асуудлыг сануулжээ.

Зава Дамдин *Алтан дэвтэр*-тээ Далай лам Абатайтай уулзаад өвөг дээдсийнхээ тахилын орныг сэлбэн засч, тэр оронд шашин, төрийг хослон дэлгэрүүлэхийг¹⁵ мөн зарлигласан гэжээ. Энд өвөг дээдсийн тахилын онгон байдаг тухай бидний өмнө дурдсан асуудал дахин хөндөгдөж байна. Зава Дамдин ямар “Өвөг дээдсийн тахилын орон”-ыг хэлсэн хэрэг вэ, бидний мэдэхгүй он дарааллын бичиг түүнд байсан юм болов уу? Чухамдаа Тахай балгасыг л хэлсэн хэрэг болов уу. Юутай ч Далай лам анхны хийд байсан газрыг газар зүйн хувьд яг нарийвчлан заагаагүй ч хуучин болон шинэ Орхон голын хооронд байх учиртай хэмээжээ.¹⁶ Тахай балгасны хувьд энэ газар тохирч байв.

¹³ Энэ оныг дараах сурвалжаас авав: Н. R. Kämpfe, *Das Asaragči neretü-yin teüke des Byamba erke daičing alias Šamba jasay* (Eine mongolische Chronik des 17. Jahrhunderts), =Asiatische Forschungen, Bd. 81, Wiesbaden 1983, 121 дэх тал. Мөн Түмэдийн Алтан хааны намтарт 1586 он хэмээсэн байдаг: К. Kollmar-Paulenz, *Erdeni tunumal neretü sudar. Die Biographie des Altan qayan der Tümed-Mongolen*, =Asiatische Forschungen, Bd. 142, Wiesbaden 2001, 332-333 дахь тал.

¹⁴ Энэ уулзалт болсон өдрийг мөн дараах сурвалжаас үзнэ үү: Н.Хатанбаатар, *Эрдэнэ зуу хийд байгуулагдсан түүхийн асуудалд, Acta Historica*, Tomus VI, Fasciculus 1-24, Улаанбаатар 2005, 85 дахь тал.

¹⁵ Зава, Дамдин, *Алтан дэвтэр*, Монгол Улсын төв номын сан, Гар бичмэлийн фонд, иш татсан Н.Хатанбаатар, Ё. Найгал, *Эрдэнэ зуугийн түүх*, Улаанбаатар 2005, 31 дэх тал.

¹⁶ *The Jebtsundamba Khutukhtus of Urga*, Text, Translation and Notes by Charles R. Bawden, =Asiatische Forschungen, Band 9, Wiesbaden 1961, 37 дахь тал.

Өдгөө ч Эрдэнэ зууд байгаа, үл анзаарагдам Хөх сүмийн тухай дээр үед настай лам нар ярихдаа “хамгийн эртний сүм” гэдэг утгаар нь Өвгөн сүм хэмээн нэрийддэг байжээ. Харин Эрдэнэ зууг байгуулсан тухай түүхийн сурвалжуудад энэ сүмийн талаар нэг ч үг дурдаагүй байна. Энэ сүм Эрдэнэ зууг байгуулагдахаас ч өмнө үүссэн, тэр ч байтугай эртний өвөг дээдсийн тахилын онгоны нэг хэсэг нь байсан юм биш биз?

Далай лам Содномжамц, Абатай хоёрын уулзалт нэн амжилттай болсон төдийгүй уг чанартаа Хубилай хаан, Пагва лам Лодойжалцан, тэрчлэн Далай лам Содномжамц, Алтан хаан нарын байгуулсан хэлэлцээрийн түүхэн шинэ нөхцөл дэх шинэ хувилбар нь болсон ажээ. Абатай улс төрийн холч? зөнгөөрөө уг гэрээ ямар боломж олгож буйг хурдан ухаарсан бололтой. “Шашин, төрийг хослон” барих нь түүнд хоорондоо зөрчилдөөнтэй Халхын ноёдын дунд гол үүргийг урьд урьдынхаас илүү гүйцэтгэх боломж олгож байв. Тэгсэн нөхцөлд түүний Тахай балгас (Хархорум) дахь орд өргөө ч урьдын нэр нөлөөнийхөө нэг хэсгийг эргүүлэн олж авч чадах байлаа.

Абатай Халх Монголд буцаж ирснийхээ дараа Далай ламын хайрласан бурхан шашны эд зүйлсийг Тахай балгасан дахь нэгэн “жигжиг” байшингийн 2-р давхарт залсан бөгөөд шинэ сүм барих ажлаар ч бас хөөцөлдөж байсан шиг байдаг. Халх монголчууд тэр үед барилга байшин барих, тэр тусмаа сүм хийд байгуулах мэдлэг, дадлагагүй байсан тул энэ ажил эхлээд түүнд ихээхэн бэрхшээл учруулсан байж таарна. Гэхдээ түүний дэргэд байсан лам нар энэ асуудлыг шийдвэрлэх арга замыг зааж өгсөн байж болох талтай. Барилгын ажлыг 1579 онд Хөх хотод барьсан хийдийн цогцолборын зураг төслийн дагуу гүйцэтгэжээ. Сүмийг барих ажилд Чин Жин Жүн¹⁷ тэргүүтэй 8 хятад дархчуулын зэрэгцээ гар урлалч лам Дархан Үйзэн Манзушир оролцож, сүмийн уран барилгачийн хувиар барилгыг шашны шаардлагад нийцүүлэн барихад мөн анхаарч байжээ. Барилгын ажлыг гүйцэтгэсэн дархчуул дээр дурдсан Хөх хотын сүмийн цогцолборыг барьж дуусгах ажилд өмнө нь бас оролцож байсан гэж ойлгогдохоор байна. Сүмийн барилгын ажил 1586 он гэхэд ихээхэн урагшилсан байв. Сурвалж бичгүүдэд Гол зуугийн сүмийн нурууг тэр ондоо босгож дууссан гэжээ. Абатай Далай ламтай зун нь уулзсанаас үзэхэд тийм ч жигжиг бус Гол зуугийн сүмийн барилгын ажил түүнээс нэлээд эрт эхэлсэн болж таарч байна. Үүний бас нэг нотолгоо нь Абатай Хөх хотоос буцаж ирэхдээ бурханч, мужаан, чулуучин, дархчуулыг л авчирсан тухай *Алтан дэвтэр*-т дурдсан явдал бөгөөд энэ нь сүмийн дотоод засал чимэглэлийн ажлыг л хийх асуудал яригдаж байсныг харуулж байна. *Эрдэнийн эрхи*-д бичсэнээр 1586 (?) онд Далай лам тус сүмд “Эрдэнэ зуу” хэмээх нэрийг хайрласан ажээ.¹⁸ Сагастерийн онцлон тэмдэглэсэнээр уг сүмд Буддагийн нэрийг хайрласан “учир нь Эрдэнэ зуу, “Эрдэнэ мэт бурхан” хэмээн бурхан (Зуу) Будда, түүхэн Будда Шагжамуни”¹⁹-г хэлсэн хэрэг бөгөөд тэр үед Буддын сургаалыг халх монголчуудын дунд дэлгэрүүлж байсан тул энэ нь санамсаргүй хэрэг биш байв. Абатай сүмийг равнайлахад Далай ламыг биечлэн залж ирүүлэх бодолтой байв. Гэвч Далай лам Сажийн ёсны Лодойнямбуу (төвдөөр Blo-gros snying-po) хэмээх ламыг илгээжээ.

¹⁷ Уг нэрийг монгол бичвэрээс авсан тул яг яаж бичдэгийг тодорхойлох аргагүй.

¹⁸ Галдан, *Эрдэнийн эрхи*, = Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал, Улаанбаатар 2006, 183 дахь тал; Дармадалаа, Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсыг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршвой, Гандантэгчинлин хийд Улаанбаатар (Хэвлэсэн он тодорхойгүй), 190 дэх тал.

¹⁹ K. Sagaster, Das Kloster Erdene Zuu (Erdenezuu), in *Dschingis Khan und seine Erben*, München 2005, 348 дахь тал.

Түүнээс хойш Эрдэнэ зуу хийдийг өргөтгөж, томоохон цогцолбор бүрдүүлснийг хэсэг тус бүрт нь, мөн он дарааллаар нь нарийвчлан тодорхойлох боломжгүй юм. Сурвалжуудын мэдээлэл хоорондоо ихээхэн зөрдөг, бас зарим монгол түүхчдийн энэ сэдвээр бичсэн нийтлэлүүдэд болгоомжтой хандах хэрэгтэй болдог.²⁰

1588 онд нас барсан Абатай хааны хүү Эрээхэй мэргэн хаан эцгийнхээ нэгэн адил Халх Монголд шарын шашныг дэлгэрүүлж хөгжүүлэх талаар хүчин чармайлт тавьж байсан ч цаад шалтгаан нь мөн л юуны өмнө прагматик-улс төрийн шинжтэй байсан буй заа. Тэр Эрдэнэ зуугийн сүм дуганын барилгын ажлыг үргэлжлүүлжээ.

Эрдэнэ зуу хийдийн анхны нэмэлт өргөтгөлийн ажлыг 1635 оныг хүртэлх хугацаанд хийсэн бололтой байдаг. Цаг хугацааны хувьд анхдугаар Жавзандамба Өндөр гэгээн Занабазар 1635 онд төрсөнтэй таарч байна. Хэрэв тэрбээр барилгыг бариулсан эзэн нь байсан бол түүхчид санаачлагыг түүнээс гарсан гэх байсан буй заа. Анх шинээр Их зуу сүмийн зүүн этгээдэд Баруун зуу сүмийг, баруун этгээдэд нь Зүүн зуу сүмийг барьжээ. Сурвалж бичгүүдэд дурьдсанаар Эрээхэй мэргэн хан, түүний их хатан Сун тайху, хөвгүүн Холачи дархан ноён болон Эрээхэй мэргэн ханы хүү Түшээт хан Гомбодорж, түүний их хатан Ханджамц нар уг хоёр сүмийг барих захиалгыг өгч бариулсан ажээ. Сун тайху, Холачи дархан ноён хоёр эрт нас барсан тул Зүүн зуугийн сүмийг хэдэн жилийн дараа бүтээсэн гэж үзэж болно. Энэхүү Эрдэнэ зуу хийдийн барилгын 2 дахь шатанд бас хэд хэдэн суварга (Түшээт ханы түшмэлүүд бариулсан), Чойжилийн сүм (төвдөөр *chos-rgyal*), Гэсэрваанийн сүм (санскритаар *Khasar-rana*; Бариулсан эзэн: Дархан үйзэн Манзушир) болон Майдарын сүм (Бариулсан эзэн: Эрээхэй мэргэн хан) баригджээ.

Түүний дараа дараачийн үйл явдлууд болон Эрдэнэ зуу хийдийн хөгжлийг зөвөөр ойлгоё гэвэл Лхас дахь Түвдийн стратегич лам нар халх монголчуудыг шашиндаа оруулахад онцгой ач холбогдол өгч байсныг бодолцох хэрэгтэй болно. Монголчууд соёлын хувьд тэдэнд ойр, дээд давхаргынхных нь дотор дээр үед Буддын нөлөө бас байсан. Түүний зэрэгцээ монголчуудын дунд шашнаа дэлгэрүүлснээр хүн ард нь уламжлалт лал, Хятадын шашнуудыг зонхилон шүтдэг нутгуудтай хил залгаа нутаг оронд нөлөөгөө үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх сайн талтай байлаа. Содномжамцын орыг залгамжилсан Далай лам Ёндонжамц (төвдөөр *Yon-tan-rgya-mtsho*, 1589-1616) Монголын Алтан хааны зээ байсныг ч юуны өмнө энэ талаас нь авч үзэх хэрэгтэй буй заа.

Гэвч халх монголчуудын дунд шашин дэлгэрүүлэх ажилд хүндрэл учирч, удаашрах болов. Халхчууд бөөгийн шүтлэгээсээ авсаар үл ангижран, шарын шашныг дэлгэрүүлэх гэсэн Абатайн зорилт дан ноёдын гэр бүлийн хүрээнд хэрэгжсэн эхний алхам л болжээ. Тэрчлэн буддын шашны сажийн ёс монголчуудын дунд нэвтэрсэн нь Лхаст зарим талаар түгшүүр төрүүлэх болов. Лхас дахь шарын шашны дээд удирдлага энэ байдалд дүн шинжилгээ хийлээ. Тэд халхчуудын дунд *гэлүгба* (*dGe-lugs-pa*)-гийн ёсыг үр нөлөөтэй дэлгэрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх хүн хэрэгтэй юм байна гэсэн дүгнэлтэд хүрэв. Энэ нь монгол хүн, гэхдээ зүгээр нэг Чингисийн угсааны хүн бус, бүр Чингисийн алтан ургийн хүн байх ёстой ажээ.

²⁰ Эрдэнэ зуу хийдийн түүхийн талаар хол давуу бүтээлийг түүхч Н. Хатанбаатар, Ё. Найгал нар туурвисныг энэхүү өгүүлэлд барилгын түүхтэй холбоотой зарим асуудлыг бичихдээ үндэс болгов. Н. Хатанбаатар, Ё. Найгал, *Эрдэнэ зуугийн түүх*, Улаанбаатар 2005.

Тэгэхлээр бүр 1588 онд нас барсан Абатайн удмын хүн л байж болох байв. Юутай ч Халх дахь Чингисийн алтан ургийнхны дотор энэ ноёны гэр бүл тэргүүлэгч үүрэг гүйцэтгэж байсан тул энэ нь нөлөөгөө түргэн тогтоох боломжийг олгохоор байлаа. Хил залгаа орнуудад гэгээн Дарнатын хувилгаан (санскритаар *taranatha*) тодрох гэж байна гэсэн цууг болгоомжтойгоор нийтэд тараав.

1635 онд Эрээхэй мэргэн ханы хүү Түшээт хан Гомбодоржийн гэрт нэгэн хөвгүүн мэндэлжээ. Тэр хүү асар их оюуны болон рид хувилгаан чадалтай гэж яригдах болов. Дөрвөн настай байхдаа л тэр убаши сахил хүртэж, Ишдорж (төвдөөр *Ye šes rdo rje*) хэмээх нэрийг авсан байна. Тавдугаар Далай лам түүнийг тэр даруй Манзуширийн хойд дүрээр тодруулжээ. Халхын ноёд 1640 онд Эрдэнэ зуугийн ойролцоох Ширээт цагаан нуурын дэргэд их ёслол үйлдэн түүнийг *очир* (*Vajra*)-ын суудалд залжээ. Харин энэ ёслолд үнэхээр Халхын ноёд бүгдээрээ оролцсон эсэх нь тодорхойгүй байдаг.

Халх монголчуудын дунд шашин дэлгэрүүлэх үйл явцыг хурдасгах даалгаврыг Лхасаас авсан лам нар Ишдоржид зөвлөгөө өгч, өөр олон сүм хийд байгуулахыг зөвлөж байжээ. Ингээд эцэст нь Ишдорж Эрдэнэ зуугаас холгүй Баруун хүрээ (төвдөөр *ri-bo-dge-rgyas-dga'ldan-hshad-grub-gling*) хийдийг байгуулсан бөгөөд тэр хийд нь хэрэг дээрээ Чингисийн угсааныханд сургаал номлол хайрлах онцгой үүрэгтэй байв. Хийдийн гол сүмд монголчуудыг хамгаалагч Очирваань (санскритаар *Vajrapāni*) бурханы баримал дүрийг залсан байв. Гол сүмийн дэргэдэх тусгай сүмд Чингис хааны хар, цагаан сүлдийг тахидаг байлаа.²¹ Ийнхүү Баруун зуу хийд нь Чингисийн алтан ургийнхны тахилгын гол газар болон хөгжсөн байжээ.

Ишдорж 15 настайдаа (1649) Түвдэд морилон Далай лам, Банчин лам нартай уулзаж, Банчин ламаас гэгээлийн сахил (төвдөөр *dGe chul*) хүртжээ. Сурвалжуудад тэмдэглэсэнээр тэр Түвдэд үлдэж шашны номыг үргэлжлүүлэн судлах хүсэлтэй байсан ажээ. Чингэхэд нь нүүдэлчин залуугийн амьдралдаа анх удаа Лхас мэтийн хотыг үзэн гайхаж, хотын амьдралд татагдсан сониуч зан тодорхой нөлөөлсөн нь лав. Гэвч Халхад шашин дэлгэрүүлэх ажил нь хүлээгдэж, Банчин лам түүнд “Монголдоо буцаж, сүм хийд байгуулан, шашнаа дэлгэрүүлэх нь амьтан болон сургаалд илүү чухал”²² болохыг анхааруулжээ. Ишдорж буцах замдаа *Брайбун* (*'Bras spruns*) хийдэд Далай ламтай дахин уулзсан байна. Далай лам түүнийг Жавзандамбын хойд дүрээр батламжилж, тамгыг нь гардуулжээ. Ишдорж 1651 онд шашны зөвлөх, жасын даамал, эрдэмтэн лам, оточ лам, Төвдийн Жан яй (*Sbyan yas*) хийдийн бурханч лам болон 50 шавийг дагалдуулан эх орондоо буцаж иржээ. Дагалдан ирсэн хүмүүс нь түүний багшийн ч, зөвлөхийн ч үүргийг гүйцэтгэж байв. Тэд залуу Ишдоржийн халхчуудын дунд шашин дэлгэрүүлэх бодлогоо үр дүнтэй явуулах баталгааг бүрдүүлэх учиртай байв.

Ингээд Эрдэнэ зуу болон Баруун зууд сууж буй лам нарын тоо асар их өсчээ. Монгол лам нар ч нэмэгдэн ирэв. Тэр үеийн халх монголчуудын нүүдлийн амьдралын нөхцөлд олон хүн нэг дор ер бусын ихээр төвлөрөх болсон нь ихээхэн хүндрэл учруулж, тэр хүмүүсийг ойр орчных нүүдэлчин ардууд хангах хэрэгтэй болсон нь өдгөө харагдаж байгаачлан тийм ч амар байсангүй. Харин лам нар аж ахуйн ажил эрхэлдэггүй байлаа. Тэд юуны өмнө Буддын

²¹ С. Ичинноров, Н. Банзрагч, *Эрдэнэ зуу хийд ба Түшээт хааны хошуу*, Улаанбаатар 1999, 14 дэх тал.

²² Н.-R. Kämpfe, *Sayin qubitan-u süsüg-ün terge, Biographie des 1. rJe bcun dam-pa-Qutuqtu Öndür gegen (1635-1723), verfasst von Nag gi dban po 1839, I. Folge, Zentralasiatische Studien 13(1979), 98 дахь тал.*

сургаалыг номлох үүрэгтэй байв. Үүний тулд сүм хийдэд байнга сууж, тогтмол хурал ном хурж байх ёстой байлаа. Тиймээс тус хоёр хийд ойр орчныхонтойгоо хоршин ажиллаж, өөрийгөө хангах хийдийн аж ахуйг үүсгэн байгуулжээ. Жавзандамбыг дагалдан ирсэн жасын даамалд энэ үүрэг оногдсон байх өндөр магадлалтай.

Жавзандамбыг дагалдан ирсэн зөвлөх лам нар Эрдэнэ зууд ирснийхээ дараа Жавзандамбыг зориуд анхаарлын төвд тавьсан зардал ихтэй олон нийтийн компанит ажил эхлүүлсэн бололтой байдаг. Тэд түүний тодорсныг магтан дуулж, сав л хийвэл Халхын цаашдын хувь заяанд үзүүлэх ач холбогдлыг нь онцолдог байжээ. Түшээт хан ч өөрийн зүгээс үүргээ гүйцэтгэж байсан, тэгэхдээ хувийн ашиг хонжоо огт харахгүй байсангүй. Далай ламын Жавзандамбаар тодруулсан хүн чухамдаа түүний хүү байсан нь бахархлыг нь төрүүлж, угтаа овгийнх нь сурвалжит язгуур угсааг товойлгож өгсөн хэрэг байв. Энэ бүхэн Эзэнт гүрний эртний нийслэлийн “тайзан” дээр болж байлаа. Зөвлөх лам нар энэ газрын түүхэн нэр нөлөөг ашиглан шашнаа дэлгэрүүлэх ажилд хүчтэй түлхэц өгөхөөр шийдэв. Тэд Жавзандамбад хүндэтгэл үзүүлүүлэхээр 1653 онд Халхын долоон хошууны ноёдыг Эрдэнэ зууд урин залжээ. Он дарааллын бичгээс үзвэл долоон хошууны ноёд тэр чуулганд цөм морилон ирсэн мэт сэтгэгдэл төрж байна. Дараа нь болсон үйл явдал зөвлөх лам нарын чадварлаг найруулан дэглэсэн ажлын үр дүн байсан нь лав. Тэд бөөгийн шүтлэгтэй ноёдод Халхад тэр үеийг хүртэл мэддэггүй байсан Бат-Оршил²³ өргөх ёслолоор Жавзандамбад хүндэтгэл үзүүлэх нь зохистой болохыг ятган сэнхрүүлсэн нь илт. Лам нарын сүр жавхлантай зохион байгуулсан ёслолын ажиллагаа энгийн зохион байгуулалттай нүүдэлчин ноёд язгууртнуудад маш өндөр сэтгэгдэл төрүүлжээ. Иймээс тэд өөрсдийнхөө нэр төрд төдийлөн харшлахгүй юм байна хэмээн үзээд лам нарын зөвлөлгөөг дуртайяа даган Жавзандамбыг Халхын шарын шашны тэргүүнээр хүлээн зөвшөөрчээ.

Гэхдээ он дарааллын бичгээс үзвэл анхны Бат-Оршил өргөх ёслолын үеэр Жавзандамба болон ноёдын хооронд ашиг сонирхлын зөрчилдөөн үүссэн байж болзошгүй байдаг. Ноёд Эрдэнэ зуу хийдийг Халхын шарын шашны гол төв болгох сонирхолтой байв. Тэдний энэхүү хүсэл эрмэлзэл ойлгомжтой байв. Хийд Эзэнт гүрний эртний нийслэлийн яг дэргэд байлаа. Хийдийг Халх Монголын шашны төв болгон хөгжүүлнэ гэдэг нь уг газрын үзүүлэх ач холбогдлыг шинэ түвшинд гаргана гэсэн үг байв. Ноёд Жавзандамбын аглагт сууж бүтээл судалгаа, уран бүтээлийн ажлаа хийхэд нь зориулж ойролцоо орших Төвхөн (төвдөөр *grub-khang*) хийдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх замаар энэ төсөлд тус хийдийг Жавзандамбын өөрийн бүтээлч бясалгал, урлагийн ажлын газар болгохыг оролдсон байж болох талтай.

Гэвч Жавзандамба Далай ламаас өөрт нь өгсөн удирдамж зааврыг санан уг төсөлд хойрго хандаж байв.²⁴ Тиймээс тэр дараа жил нь Хэнтийн уулс тийш явж, тэнд *Рибо гэжсай гандан шаддувлин* (Ri bo dge rgyas dga ldan bšad grub glin) хийдийг байгуулж, түүнийгээ өөрийн төвлөн суух хийд хэмээн зарлажээ. Энэ нь цаашдаа Эрдэнэ зуугийн хувьд хүнд үр дагавар авчрахаар шийдвэр байсан учир нь тус хийд хожим Гадаад Монголын хамгийн том хийд, улс төр-шашны төв Их Хүрээ болон хөгжсөн билээ (өнөөгийн Улаанбаатар).

Энэ үед Эрдэнэ зууд Рэгсүмгомбо (төвдөөр *rigs-sum-mgon-po*)-ын сүм байгуулагдаж, Түшээт ханы түшмэл Гүүш дархан Зайсан түүнийг бүтээлгэснээ Жавзандамбад өргөжээ. Хөх тоосго

²³ K. Sagaster, Das Kloster Erdene Zuu (Erdenezuu), *Dschingis Khan und seine Erben*, München 2005, 349 дэх тал.

²⁴ С. Пүрэвжав, *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*, Улаанбаатар 1978, 44 дэх тал.

өрж барьсан уг сүм Манзушир, Жанрайсиг, Очирваань бурхдад зориулагдсан бөгөөд эргэн тойрон хашлага ханаар хүрээлэгдсэн байжээ. Тэр үед мөн Номун ханы сүм баригдсан бөгөөд Түшээт хан Чахундорж, Өндөр Гэгээн нар мөн өөрсдийн эхийн дурсгалд зориулан Хонсим бодисатвагийн сүмийг бариулсан байна.

Ноёдын чуулган Далай ламын хувьд томоохон ялалт авчирчээ. Түүний “хуурай хүү” *гэлүгба* (dGe-lugs-pa)-гийн ёсыг баримтлагч Жавзандамбыг Халхын шарын шашны тэргүүнээр хүлээн зөвшөөрсөн нь юун түүрүүнд халхчуудын дунд багагүй нөлөөтэй болоод байсан *сажаба* (Sa-skya-pa)-гийн ёсыг баримтлагчдын эсрэг хийсэн шийдвэрлэх нүүдэл байв. Далай ламын төлөвлөсөн стратеги зорилтыг Бээжин дэх Чин улсын ордныхон ч үлэмж сонирхон анхааралдаа авчээ. Тэд өөрсдийнхөө эрхшээлд оруулахыг санаархаж байсан Халхад болж буй үйл явдлыг эртнээс анхааран ажиглаж байсан юм. Халх монголчуудад үзүүлж байсан Далай ламын нөлөөг ашиглахаас өөр хэрэгтэй юм гэж юу байх билээ? Эзэн хаан Энх-Амгалан 1652 онд буюу Эрдэнэ зууд ноёдын чуулахаас нэг жилийн өмнө Бээжинд Далай ламтай уулзан түүнд ихэд найр тавин шадарлажээ. Далай лам энэ байдлыг өөрийнх нь төлөөлж буй шашинд хандсан хандлага хэмээн ойлгосон бол Энх-Амгалан Төвд болон Халх Монголыг эрхшээлдээ оруулах тухай бодож байв.

1657 онд Эрдэнэ зууд дахин чуулсан ноёдын чуулганд юуны өмнө Халхын зүүн дөрвөн хошууны ноёд оролцжээ. Жавзандамба дөнгөж урьд жил нь Түвдээс буцаж ирсэн байв. Энэ удаагийн арга хэмжээ нь Чингисийн алтан ургийнхныг тахин шүтэх, шашны суртал нэвтрүүлгийн чадварлаг найруулсан эвлүүлэг болсон байна. Ичинноров, Банзрагч нарын бичсэнээр “Монгол төрийн гал голомт” гэгдэж байсан Абатайн гэрийн дэргэд Жавзандамба, Түшээт хан нар нэгэн их гэрийг бариулж, түүнийгээ “Бат-Өлзийт” хэмээн нэрийджээ. Энэ гэрт өдөр бүр *ганжуур* (bKa-'gyur) хурж²⁵, уг хуралд ноёдын чуулган болох үеэр зүүн дөрвөн хошууны төлөөлөгчид цом суудаг байв. Ийнхүү *ганжуур* (bKa-'gyur)-ын хурлыг зохион байгуулалтад оруулсан нь Эрдэнэ зуу хийдийг *гэлүгба* (dGe-lugs-pa)-гийн ёсны нөлөөнд бүрэн автахад хүргэжээ.

Жавзандамба энэ уулзалтын үеэр төр, шашны харилцаа, дан шашны асуудлуудад анхаарлаа хандуулж байсныг он дарааллын бичгүүдэд онцлон тэмдэглэсэн байдаг. Тэрбээр Халхын шашны тэргүүн, ноёдын дунд тэргүүлэгч Чингисийн алтан ургийн гэр бүлээс гаралтай хүн байсан тул энэ нь тийм ер бус хэрэг байгаагүй ч үйл ажиллагааных нь цаанаас шинэ санаархал цухалзаж байсан байж болох талтай. Төр, шашны эрх мэдлийг өөртөө төвлөрүүлэх санаатай байсан юм болов уу?! Юутай ч түүнд нь нийцэх үүнээс өөр тохиромжтой газар олдохгүй байсан буй заа.

Мөн ноёдын чуулганы үеэр Эрдэнэ зууд янз бүрийн сүмийн барилгыг шинээр ашиглалтанд оруулсан бололтой байдаг. Сурвалжуудын мэдээлснээр 1657 оны хавьд Эрдэнэ зуугийн хоёрдугаар ширээт лам Лобомба Санжаадаш Шагжамунийн болон Манзуширийн сүм байгуулан хоёр суварга бүтээгдсэн ба Жавзандамбад зориулсан нэгэн сүмийг Түшээт ханы түшмэл Гүүш дархан Зайсан Ригсүмгомбо бариулсан байна.²⁶

²⁵ *Монголын хурээ, хийдийн түүх* (Эмхэтгэл), Эмхэтгэсэн Ч. Банзрагч, Б. Сайнхүү, Улаанбаатар 2004, 8 дахь тал.

²⁶ Мөн тэнд, 8-9 дэх тал.

Түшээт хан Чахундорж 1673 онд Төвдэд очиж, дараа жил нь Далай ламд бараалхжээ. Далай лам түүнд Очирай сайн хан цол соёрхсон байна.²⁷ Түшээт хан 1675 онд буцаж ирээд Далай ламыг хүндэтгэн Эрдэнэ зууд нэгэн сүмийг байгуулсан нь Далай ламын сүм хэмээн нэрлэгдэх болжээ. Мөн тэр үед Цамбын сүмийг байгуулсан байна. Түүнээс гадна Түшээт хан, Жавзандамба нар Эрдэнэ зуугийн зүүн хойд талд өөрсдийн эх Ханджамцын дурсгалд зориулж нэгэн суваргыг бүтээлгэсэн бөгөөд тэнд Ханджамцын шарилыг оршуулсан бололтой байдаг.

Халхын ноёд Өндөр гэгээн Занабазарын 47 нас сүүдэр тохиосны ойд зориулж Бат-Оршил өргөх ёслол үйлдэхээр 1681 онд дахин Эрдэнэ зууд цуглав. Ачит зурхайч гэлэн Лувсанданзан Өндөр гэгээний насны ойд зориулж Авид бурханы сүмийг байгуулж өргөснийг уг уулзалтын үеэр равнайлсан бололтой. Тэр үед тус хийд өдгөө бидний мэдэх гадаад их хэрмээр хүрээлүүлж байсан байж таарна, учир нь сурвалж бичигт тэмдэглэснээр Эрдэнэ зуугийн гутгаар цорж лам Ачит цорж Лувсан-Осор хэрмийн дөрвөн өнцөгт тус бүр нэгжгээд суварга босгуулсан байжээ. Ийнхүү Эрдэнэ зуу хийд нэгэн томоохон цогцолбор болон бүрэлджээ. Гадаад их хэрмийн тал тус бүрийн урт нь 400 м. Мөнөөх Ачит цорж Лувсан-Осорын санаачлагаар гурван хуучин сүмийн өмнө Абатай хаан, Түшээт хан Гомбодорж нарын бунхныг босгосон байна. Харин хэзээ энэ хоёр бунханыг барьж дуусгасныг баттай хэлэх боломжгүй. Гурван зуугийн цогцолборын өмнөх тэдгээрийн тэгш хэмтэй байрлал, харахад адил төстэй байдал нь юутай ч уран барилгачид ижил цаг хугацаанд бүтээн уран барилгын чуулбарт оруулж өгснийг илтгэнэ. Түшээт хан Гомбодорж 1655 онд нас барсан тул уг хоёр бунхныг 1655 оноос хойш барьсан байж таарах нь.

Гэвч Эрдэнэ зуу хийдийн цэцэглэн мандалт 17-р зууны 80-аад оны үед гэнэт тасалджээ. Баруун Монголын Галдан бошигт хаан Халхын зарим ноёдтой эрх мэдлийн төлөө дайтав. Галдан бошигт хаан 1688 онд гурван түмэн цэрэг авч Халх Монголд дайран оржээ. Тэр юуны өмнө өөрийн хамгийн хүчтэй өрсөлдөгчид хэмээн үзэж байсан Түшээт хан Чахундорж, Жавзандамба нарыг үлдэн хөөсөн байна. Тэр Жавзандамбыг Эрдэнэ зууд байгаа гэж сонсоод цэргээ тийш нь илгээжээ. Цэргүүд нь Эрдэнэ зууд хүрч очиход Жавзандамба зугтсан байсан ч, энэ нь Баруун Монголын цэргүүдийг хийдийн цогцолборыг эвдэн сүйтгэхэд саад болсонгүй.

Халхын ноёд Галдан бошигт хаантай байлдаж ахуйдаа Манж Чин улсын Энх-Амгалан хаанаас тусламж гуйхаас өөр аргагүй болов. Тэдний тусламж хүссэн хүсэлт нь эцэстээ 1691 онд Долоннуурын чуулганы үеэр Энх-Амгалан хааны хүрэлцэн ирж оролцсон Манжийн эрхшээлд орох сүр жавхлантай их ёслолын ажиллагаанд хүргэжээ. Энх-Амгалан хаан Түшээт хан, Жавзандамба нарт Халхын ноёдын дотор Түшээт ханы овгийнхны эзэлж байсан онцгой байр суурьт тохирсон асар их хүндэтгэлийг үзүүлсэн ажээ. Халхын гурван ханаас Түшээт хан л Энх-Амгалан хааны өөрийнх нь хэрэглэж байсантай ижилхэн эзэн хааны асар нэгийг, мөн нэгэн монгол гэрийг бэлгэнд авчээ. Харин Түшээт хан Чахундоржийг Халх Монголд суурьшуулах газрын асуудал яригдахад Хархорум, Эрдэнэ зуу хоёрын алиныг нь ч боломжгүй

²⁷ V. Veit, Die vier Qane von Qalq-a, Teil II: Biographien, =Asiatische Forschungen, Bd. 111, Wiesbaden 1990, 53 дахь тал; Н.-Р. Kämpfe, Sayin qubitan-u süsüg-ün terge, Biographie des 1. rJe bcun dam-pa-Qutuqtu Öndür gegen (1635-1723), verfasst von Nag gi dban po 1839, 1. Folge, Zentralasiatische Studien 13(1979), 100 дахь тал.

байсан юм. Хаан түүнд Туул голын зүүн этгээд дэх Халиар ууланд суурьших заавар өгсөн байна. Энэ талаар Гадаад мужийг засах явдлын яам (*Li-fan-yuan*)-ны овог аймгийн сударт: “Тэр газар Эрдэнэ зуугийн зүүн хойд этгээдэд оршдог”²⁸ хэмээсэн нь бараг тайвшруулах өнгө аястай сонсогдож байв, учир нь Туулын ойролцоох түүний шинэ өргөө, Эрдэнэ зуу хоёр хоорондоо хол зайтай байлаа. Жавзандамбыг ч мөн Эрдэнэ зуугаас алс байлгажээ. Энх-Амгалан хаан түүнийг тэр жилдээ Бээжинд өөр лүүгээ урьж, “цагтаа Далай ламд үзүүлж байсан шигээ хүндэтгэл үзүүлэн хүлээж авсан”²⁹–аас хойш тэр 1700 оныг хүртэл тэндээ байжээ. Харин тэр бээр 1700 онд (ах Түшээт хан Чахундорж нь 1699 онд нас барж, Чахундоржийн хүү Дондовдорж 1700 онд хан ор суусантай холбоотойгоор бололтой) эх орондоо буцаж ирсэн даруйдаа дайнд ихэд сүйрсэн хийдийг сэргээх зааварчлага өгөхөөр 1701 онд Эрдэнэ зуу руу явсан нь анхаарууштай. Манжийн эзэн хаан тэр жилдээ дахиад Бээжинд түүнтэй уулзахыг хүссэн нь чухам энэ алхамд нь дургүйцсэнийх байж болох талтай. Юутай ч халхчууд Бээжингийн ордныхны нүдэнд Чин улсын хааны харьяат болж харагдах болсон байлаа. Тиймээс ч эзэн хаан болон түүний хятад зөвлөхүүд Чингисийн алтан ургийнхныг тахин шүтэх аливаа оролдлогод ихээхэн үл итгэсэн байдлаар хандах болжээ.

Эрдэнэ зууг сэргээн засварлах ажил эхэндээ нэн удааширч байв. Энэ ажлыг гүйцэтгэхэд нь хийдэд мөнгө их хэрэгтэй байлаа. Тэр үед Халхын ноёдоос мөнгө гаргуулах боломж бараг байхгүй байв. Энэ нь янз бүрийн шалтгаантай байжээ. Нэг талаас 1691 оны өмнөх дайны эдийн засгийн үр дагавар арилаагүй байсан, нөгөө талаас XVIII зууны эхэн үеийн Халх Монголд зах зээл ч олигтой хөгжөөгүй, мөнгө санхүүгийн тогтолцоо ч бүрэлдээгүй байв. Сурвалжуудад сүм хийдийг бариулсан эзэд буюу өглөгийн эздээр зөвхөн монголчуудын нэрийг дурддаг ч наад захын барилгын гүйцэтгэлийн ажил гэхэд л хятад гар урчуудын гарт байв. Тэд ажлынхаа хөлсийг байгалийн бүтээгдэхүүнээр бараг авдаггүй байсан бололтой. Түүний дээр зарим материалыг алс холын Өвөр Монголоос тээвэрлэж авчирдаг байсан тул бас л их зардал шаарддаг байжээ.

Жавзандамба Өндөр гэгээн Занабазар 1723 онд Бээжинд нас баржээ. Түүний шарилыг Монголд авчирч, эхлээд өөрийнх нь үүсгэн байгуулсан *Рибую гэжэй гандан шаддүвлин* (*gi-bo-dge-rgyas-dga' ldan-bshad-grub-gling*) хийдэд оршуулсан байна. 1778 онд шарилыг нь алс хойд зүгт орших Чин улсын хааны онцгой эрх соёрхсон Амарбаясгалант хийдэд шилжүүлэн оршуулжээ. Жавзандамба өөрөө Эрдэнэ зуутай хэр ойрын холбоотой байсан талаас нь авч үзвэл шарилыг нь энэ хийдэд оршуулах учиртай байсан ч Чин улсын эзэн хааны ордныхон Эрдэнэ зууд оршуулахыг улс төрийн шалтгаанаар зохимжгүй гэж үзсэн бололтой байдаг. Жавзандамбын орыг залгамжлуулах асуудлыг дахиад л Түшээт ханы овгийнхны дотор зохицуулсан байна. Түшээт хан Чахундоржийн ач, Чин ван Дондовдоржийн 1724 онд төрсөн дөтгөөр хүүг II Жавзандамбын хойд дүрээр тодруулжээ.³⁰ Харин түүнийг дахин тодруулах, Чин улсын засаг захиргаагаар батламжлуулах ажил удаашрах болов. Ордныхон Далай лам болон Банчин ламаар батламжлуулахын тулд Дашчоймпил тойныг Лхаст илгээжээ. Бээжингийн ордныхон энэ батламжийг гаргуулж авсныхаа дараа л түүний хойд дүрийг батламжилж, алтан тамга соёрхохоор болов. 1728 оны 6-р сарын 22-нд II Жавзандамбад

²⁸ V. Veit, Die vier Qane von Qalq-a, Teil II: Biographien, =Asiatische Forschungen, Bd. 111, Wiesbaden 1990, 57 дахь тал.

²⁹ H.-R. Kämpfe, Sayin qubitan-u sūsüg-ün terge, Biographie des 1. rJe bcun dam-pa-Qutuqtu Öndür gegen (1635-1723), verfasst von Nag gi dban po 1839, 2. Folge, *Zentralasiatische Studien* 15(1981), 331 дэх тал.

³⁰ V. Veit, Die vier Qane von Qalqa, Teil II: Biographien, =Asiatische Forschungen, Band 111, Wiesbaden 1990, 65 дахь тал.

Бат-Оршил өргөж хүндэтгэл үзүүлэхээр Халхын бүх хошууны элч төлөөлөгчид Хүрээнд цуглав.³¹ Ийнхүү II Жавзандамбыг тодруулсан явдал Эрдэнэ зуу хийдийг дахиад хөхиүлэн дэмжинэ гэсэн итгэл найдварыг төрүүлэх болжээ. Гэтэл Ойрадын дараачийн довтолгоон энэ итгэл найдварыг нь талаар болголоо.

Зүүнгарын хаан Галданцэрэнгийн ойрад цэрэг 1732 онд Халхад довтлов. Тэд Эрдэнэ зууд цөмрөн оржээ. Хэдийгээр манжууд тэр үед Эрдэнэ зууд заларч байсан II Жавзандамбыг Долон нуурт амжин авчирсан ч цэргүүд хийдийг эзэлж, эвдлэн сүйтгэхээс сэргийлж чадсангүй. Ойрадууд хийдийг эзэлсэн нь нэг талаар “Монгол төрийн гал голомтыг” гартаа авах гэсэн тэдний хуучин санаархалтай холбоотой ч нөгөөтэйгүүр Эрдэнэ зуу тэр үед урьдын адил Халх Монгол дахь хамгийн гол стратегийн төв болж байсныг харуулж байна. Харин эзэн хааны цэрэг Эрдэнэ зуугийн зүгт нэгэнт хөдөлсөн байлаа. Эзэн хааны цэрэг тэр жилдээ ойрадуудыг хийдийн ойролцоо бут цохисон байна.

Ойрадын довтолгооноор Эрдэнэ зуу хийд ихээхэн сүйдэж, барилга байгууламж нь ихэд эвдэрч, ойр орчмынх нь нүүдэлчин ардууд ядуурчээ. Ойрадын цэргүүд ч, Манжийн цэргүүд ч өөрсдийгөө хангахын тулд ойр орчмын нүүдэлчдийг тонон дээрэмдсэн байлаа. Мал сүрэг ихээхэн хорогдож, олон ч хүн амь насаа алджээ. Үүний улмаас томоохон хийд болох Эрдэнэ зуугийн хангамжийн асуудал хүндэрчээ. Олон лам нүүн шилжив. Сүсэгтнүүд өглөг барьц өргөхөө больж, барилга шинээр барих, засварлах аргагүй болов. Хийдэд шийдвэрлэхэд бэрхтэй асуудлууд тулгарав. Эрдэнэ зуугийн гутгаар ширээт цорж Лувсанванчин 1718 онд Очирдарийн сүмийг байгуулсны дараагаас барилгын ажил дахиад зогсож, дайн байлдаан дахин дэгдсэн нь хийдийн цаашдын хөгжилд сөргөөр нөлөөлөх болов.

II Жавзандамба Хүрээн дэх өөрийн төвлөн суудаг хийдэд амьдрах болжээ. Эрдэнэ зууд суух нь Бээжин дэх ордныхны таалалд нийцэхээ больсон байлаа. Хүрээнд сууснаараа тэр Чин улсын засаг захиргааны шууд хяналтад оров. Түүний зэрэгцээгээр манжууд Түшээт хан Дондовдоржийг “хамгаалалтанд авах”-аар 1741 онд Хүрээнд ирүүлсэн байлаа. Тэглээ ч II Жавзандамба 1743 онд Эрдэнэ зууд нууцаар очсон байна. Түүнийг тэнд машид хүсэн хүлээж байжээ. Тэр ч байтугай Эрдэнэ зуугийн VI ширээт цорж Шидэт дархан цорж билигт Лувсанцэдэн түүнийг хүндэтгэн Шагжамуни бурханы нэгэн бяцхан сүмийг бариулсан байв. Тэр сүм хийдийн сүйдсэн барилга байшингийн дунд итгэл найдварын бэлгэ тэмдэг мэт харагдаж байжээ.

Харин Чин улсын засаг захиргаа Түшээт ханы гэр бүлийнхнийг хаашаа ч хамаагүй явахыг зөвшөөрөхөө болив. Энэ Түшээт ханд II Жавзандамбын Эрдэнэ зууд нууцаар очсоны хариуцлагыг хүлээлгэв. Эзэн хаан түүнийг буруушаан зэмлэлээ. Түшээт хан тэр жилдээ нас барсан нь санамсаргүй явдал байв уу үгүй юү гэдэг нь тодорхойгүй. Түүний орыг залгасан Дондовдорж ч ганцхан жил л амьдарчээ. Түүнийг залгамжлагч Ямпилдорж 1746 онд Түшээт хан цолыг залгамжлан авсан ч 1756 онд “өвчилж” албаа орхижээ. Гэхдээ ийнхүү “өвчилсөн” нь цаанаа учиртай байсан ажээ. 1755-1757 онд Амарсанаа, Чингүнжав нарын ноёд Манжийн ноёрхлын эсрэг бослого гаргаж, Чин улсын ордныхон Ямпилдоржийг “албат нараа номхотгож” чадсангүй хэмээн зэмлэн буруушаасан ажээ. Мөн түүнийг хүү Ванчиндоржоо “дураар нь гэрт нь буцааж” ирүүлсэн хэмээн буруутгажээ. (Хаашаа? Эрдэнэ

³¹ Чийрэгхүү, *Жавзандамба хутагтын товч намтар*, Хөх хот 1992, 78-79 дэх тал; Х. Г. Жамсранжав, II, III Богд, “Монголын 100 хаан, найман Богд” цуврал, Улаанбаатар 2001, 24 дэх тал.

зуу руу юу?!) Түшээт хан, II Жавзандамба нар Хүрээнд манжуудад барьцаалагдсан хэрэг! Түшээт ханы гэр бүлд “их үхэл” нүүрлэжээ. 1757 онд II Жавзандамба, дараа жил нь Түшээт хан Ямпилдорж “нас барав”. Түшээт ханы орыг түүний ач Цэдэндорж залгамжиллаа.³²

Манжууд Халх Монголын улс төрийн байдалд дүн шинжилгээ хийлээ. Ингээд тэд нэгэн зарчмын асуудлыг ухаарав. Жавзандамбын нөлөөний хүрээнд Гадаад Монголд 65 орчим сүм хийд, мөн улс орноор хяналтгүй хэрэн хэсүүчилж явдаг олон тооны лам орж байв. Шарын шашны энэхүү сүлжээ *Li fan yuan*-аас “гадаад мужууд”-ад зориулан гаргасан хуулиас гадуур үйл ажиллагаа явуулж байсан төдийгүй, зарим үед түүнийг Лхасаас удирдан залж байв. Халх Монголд эрх мэдлээ бататгая гэвэл эдгээр бүтцийг албан ёсны хяналтанд авах ёстой гэдэг дээр Бээжин дэх *Li-fan-yuan*-д санал нэгдэв. Ингээд Чингисийн алтан ургийн ноёд язгууртнууд болон Жавзандамбын хоорондын цусан төрлийн холбоог тасалж, Жавзандамбын хойд дүрээр зөвхөн төвд хүнийг тодруулж байх шийдвэр гаргав. Бусад хутагт хувилгаадын хойт дүрийг ч Чингисийн алтан ургийн ноёд язгууртнуудын дундаас тодруулахыг 1793 онд хориглож, үүнийгээ 1815 онд хуульчилжээ. Тэрхүү хууль зарлигт Жавзандамбын хойд дүрүүдийг Төвдэд тодруулж байхыг дахин онцолсон байлаа. 1815 онд гаргасан “Зарлигаар тогтоосон Гадаад мужуудын засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-ийн “Лам нарын хууль”-ийн (манжаар *hese i toktobuha tulergi golo be dasara jurgan i kooli hacin i bithe*) 58 дугаар ботид: “Монгол Фанзегийн аймгаас хутагт ихээхэн ламын хувилгаан дэлгэрэв хэмээн өргөн мэдүүлвээс сул тайж эс бөгөөс албат ард жич Тангудын харц хүмүүний хөвгүүдийн дотроос заалгуул. Далай лам, Банчин Эрдэнийн төрөл ураг, жич олон монгол хан, ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж нарын хөвгүүд ач нарын дотроос хувилгаан заахуйг нийтээр цаазлагтун.”³³ хэмээн заажээ. Ийнхүү Монголд шарын шашны хутагт хувилгаадыг тодруулахад Бээжин дэх *Li fan yuan*-нд бүртгүүлж, батламжлуулах шаардлагатай болов. Чингисийн алтан ургийн ноёд язгууртнууд, шарын шашны санваартан хуврагуудын хоорондын сүлжээ задарлаа. Түшээт ханы овгийнхны их бага ямар нэг хэмжээгээр үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн “Төр, шашныг хослон барих” зарчмыг хэрэгжүүлэх боломжгүй болов.

Эдгээр арга хэмжээг авсны улмаас Халх Монголд төрсөн сэтгэгдлийг зөөлрүүлэх үүднээс Чин улсын засаг захиргаа Монголын сүм хийдүүдэд улам их материаллаг дэмжлэг, санхүүгийн хөнгөлөлт үзүүлж, төрөл бүрийн татаас олгож байв. XVIII зууны хоёрдугаар хагаст Эрдэнэ зууд барилгын ажил дахин өрнөж эхэлсний нэг шалтгааныг эндээс хайх хэрэгтэй буй заа. Түүний хамтаар нөхцөл байдал тогтворжсон байна. Халх Монголд Хятадын худалдааны пүүсүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, сүм хийдүүдийг тойрсон зах зээл суурингууд бий болжээ. Эзэн хааны ордноос цалин пүнлүү олгох, тэр хэрээр ноёд язгууртнууд хөлжин улам чинээлэг болж байв. Хүмүүс шашин шүтэх нь ихэссээр шарын шашин амьдралд нь бат байр суурь эзлэх болов. Итгэл сүсгээрээ өргөл барьц өргөн бурханы ивээлд хойт насаа даатгах нь ихсэв.

Энэ хандлага Эрдэнэ зуугийн цаашдын хөгжил цэцэглэлтэд эерэг нөлөө үзүүлэх болов. Лам нарын шинэ шавь нар олноороо ирж хийдэд шавилан суух болов. Бурханы ном хуруулах сүсэгтнүүдийн тоо зогсолтгүй нэмэгдэв. Тэрчлэн сүм хийдийн аж ахуйд ажиллагчдын тоо ч

³² V. Veit, Die vier Qane von Qalqa, Teil II: Biographien, =Asiatische Forschungen, Band 111, Wiesbaden 1990, 59 дэх тал.

³³ *hese i toktobuha tulergi golo be dasara jurgan i kooli hacin i bithe, susai jakūci debtelin, lamasai kooli, hūbilgan be jorige toktobuha kooli.* Эрдэм шинжилгээний өгүүллийн манж хэлээрх тусгай дугаар.

байнга өсч байлаа. Тиймээс зарим хэсэг нь муудсан байшин барилгууд нь шаардлага хангахаа больжээ. Хуучин барилга байшинд их засвар хийх, шинэ сүм дуган, аж ахуйн барилга барих шаардлагатай болжээ.

Эрдэнэ зуу хийдийн VII цоржоор Түшээт ханы 1760 онд томилсон эрдэмтэн лам Дагвадорж (1734-1803) энэ ажлыг гүйцэтгэх болжээ. Дагвадорж барилга байшинг засаж сэлбэх, шинээр барих ажлыг эрчимтэй урагшлуулсан байна. Лам нар болон сүсэгтнүүд 1760 онд гэлэн Данзангийн удирдлага дор Эрдэнэ зууд Бурхадын сүм, Хүрдийн сүм гэсэн хоёр шинэ сүмийг бариулжээ. Дагвадорж Зонховын сүм, Ямандагийн сүмийн барилгын ажлыг 1765 онд дуусгуулжээ. Тэр бээр сүмийг барих хөрөнгийг Түшээт хан аймгийн Санжаадорж вангийн хошуунаас гаргуулсан тул уг сүм Вангийн харьяат сүм нэрээр хийдийн түүхэнд оров.

Дагвадорж хийдэд гурван давхар том хурлын сүм байгуулъя гэж эртнээс боддог байжээ. Энэ том ажлыг бүтээхэд их хэмжээний хөрөнгө мөнгө шаардлагатай байснаас болж Түшээт хантай тэр байнга муудалцдаг байв. Тиймээс тэр Халх Монголын хошуудаас уг сүмийг байгуулах хөрөнгийг цуглуулах зөвшөөрлийг Жавзандамбаар гаргуулж авчээ. Жавзандамба түүний хүсэлтийг ёсоор болгосон тул тэр Түшээт хан, Сэцэн хан аймгийн олон хошуугаар явсан байна. Явсан ажил нь ч амжилттай бүтжээ. Тэр шаардлагатай мөнгийг олж, сүм бариулах захиалгаа ч өгчээ. 1770 онд Цогчин дуган (төвдөөр *tshogs-chen 'du-khang*)-ы барилгын ажлыг дуусган ашиглалтад оруулав.

Ингээд Дагвадорж 1784 онд засварлах нэн шаардлагатай болсон Махагал, Гомбогүр, Манал бурханы сүмүүдийг нэгтгэж, нэг хэрмээр хүрээлэгдсэн таван байшин бүхий цогцолборыг байгуулжээ. Уг цогцолборын гол төвд, төвд маягийн хийцтэй Махагалын сүм байсан нь 1803 онд IV Жавзандамбын байрлаж байснаас хойш Лаврин (төвдөөр *bla-brang*) нэртэй болжээ. Дагвадорж сүм дуган бариулах ажилд өргөл барьц өргөх хандивлагчийг олноор нь татан оролцуулж чаддаг байв. Тухайлбал Түшээт хан аймгийн гүн Содномчоймбил 1771 онд Аюушийн сүмийг бариулж, түүнийг Дагвадорж өөрөө равнайлсан байна. Тэрчлэн 70-аад оны үед Дагвадоржийн багш Лувсанчогдон Манзушир, Ямандагт зориулсан хоёр сүм бариулжээ. Дагвадоржийн санаачлагаар Өвөр Монголын уран барилгач Буяндалай 1796 онд өмнө нь байсан Далай ламын сүм, Цамбын сүм (төвдөөр *thsang-pa*), Зонховын сүм, Аюушийн болон Ямандагийн хоёр сүмийг Очирваанийн цогцолбор болгон нэгтгэж, Мөнх зулын сүмийг барьжээ. Сүүлд нь 1799 онд хийдийн цогцолбор байгууламжийн гол төвд орших Алтан суваргыг Дагвадорж IV Жавзандамбын 25 насны ойд зориулан бариулсан байна. Өөрийнхөө нас барсан жил болох 1803 онд ч Дагвадорж Хонсим бодисатвагийн сүм, Жанрайсигийн (төвдөөр *spyan-ras-gzigs*) сүмийг бариулж бэлэн болгосноороо хоёр чухал төслийг дуусгасан юм.

Анх шороон далан хэлбэрээр баригдсан байсан хийдийн хэрмийг сэргээн засварлах, зарим хэсгийг нь шинээр барих ажил хамгийн их хүч, хөрөнгө шаардсан ажлуудын нэг байсан бололтой. Уг шороон далан хэрэм ч суваргуудтай байсан, харин тэдгээрийн дээр өглөгийн эздийн нэрсийг бичсэн бичээс байхгүй байжээ. Хэрмийг шинээр барих, шинэ шинэ суварга босгох ажил нэлээд удаан хугацаагаар үргэлжилсэн байна. Энэ ажил XVIII зууны 30-аад онд эхэлж, 1808 онд дуусчээ. 1802 онд хэрмийн нэлээд хэсгийг шинэчлэх, 50 орчим суварга бүтээх захиалгыг дээр дурдсан Өвөр Монголын уран барилгач Буяндалайд өгч, суваргын яндарт? тэдгээрийг бүтээсэн өглөгийн эздийн нэрс зэргийг чулуунд сийлж шигтгэсэн байна.

Дээрх ажил дууссаны дараа хийдийн хэрэм нийт 108 суварга, тал бүртээ нэжгээд хаалгатай болсон байлаа. Хийдийн цогцолборын өмнөд этгээдийн гоёмсог гол хаалгыг 1803 онд IV Жавзандамбыг Эрдэнэ зууд морилохыг тохиолдуулан барьсан байна. Хэрмийн цогцолборыг сэргээн засварлах дараачийн шатны ажил 1881-1890 онуудад үргэлжилжээ.

Сүм дуган, аж ахуйн барилгууд, мяндагтан лам нарын сууцнаас бүрдсэн Эрдэнэ зуугийн барилга байгууламж XVIII зууны сүүлч, XIX зууны эхэн үед голлон бүрэлдэж цогц шинжээ олжээ. 1872 онд Эрдэнэ зууд 62 сүм буюу сүмтэй төстэй барилга байгууламж бий болсон байв. Аж ахуйн барилгууд, том лам нарын сууцтай нийлээд энэ үед Эрдэнэ зуу 500 орчим барилга байшинтай болсон байлаа.

Хийдийн нөлөө нэмэгдэхийн хэрээр Эрдэнэ зууд амьдрах лам нарын тоо өсчээ. Лам нарын тоо Эрдэнэ зуугийн VII цорж Дагвадоржийн ажиллаж байсан хугацааны эцэст 500 хүрч, XX зууны эхэн гэхэд 1500 орчим болж нэмэгдсэн байв. Гэхдээ Эрдэнэ зууд байнга амьдарч байсан лам нараас ямар нэг хэлбэрээр хийдийн харьяанд байсан ч гадуур хэрэн явж байсан лам нарыг ялгаж салгаж үзвэл хийдэд байнга сууж байсан лам нарын тоо XX зууны эхэнд 500-гаас хэтэрдэггүй байсан гэж үзэж болно.³⁴

Эрдэнэ зуу богино хугацаанд мандан цэцэглэсэн ч Гадаад Монголын энэ хийд гол үүрэг гүйцэтгэхээ болиод удсаныг анхаарахгүй байж болохгүй. Энэ нь олон янзын шалтгаантай. Эрдэнэ зуу. Хархорумын аугаа их түүхээс улбаалан энэ газар нь тусгаар тогтнолын төлөө тэмцлийн гол төв болж хувирах аюулыг байнга дагуулж байсан тул Чин улсын засаг захиргаа эрх мэдлээ хадгалах тодорхой бодлогын үүднээс Эрдэнэ зуугийн гүйцэтгэж байсан шашны төвийн үүргийг хязгаарлахыг сонирхож байсан явдал гол шалтгаан нь байсан буй заа. Төвд хойд дүүрүүд нь Эрдэнэ зуутай сэтгэлийн гүн холбоогүй байсан ч гэсэн Жавзандамбыг Хүрээнд байлгах нь Бээжингийн ордныхонд зайлшгүй чухал байжээ. Жавзандамбын хувилгаанууд тус хийдэд ховорхон заларч байв. Бидний танилцсан он дарааллын бичгүүдэд дурдсанаар Эрдэнэ зууд IV Жавзандамба зөвхөн нэг удаа 1803 онд, VIII Жавзандамба хоёр удаа заларсан байна. Түүний дээр Чин улсын эзэн хаад 1727 онд Амар баясгалант хийдийг, 1761-1765 онуудад Дамбадаржаа хийд-ийг ихээхэн санхүүгийн хөрөнгө хүч гарган Жавзандамбын өргөө-хийдийн ойролцоо бариулжээ. Онцлог нь Жавзандамба хутагтуудын шарилыг бүгдийг нь Амарбаясгалант, Дамбадаржаа, Гандантэгчинлэн хийдүүдэд л оршуулсан байдаг.

1809 онд Хүрээнд Гандантэгчинлэн хийдийг байгуулснаар (төвдөөр *dGa'-ldan theg-chen-ling*) Эрдэнэ зуугийн нөлөө яваандаа буурахад хүрчээ. Гандантэгчинлэн богино хугацаанд Гадаад Монголын гол хийд болон хөгжив. 1844 оныг хүртэл түүний харьяанд байгуулагдсан арваад дацан идэвхтэй үйл ажиллагаа явуулсны дүнд Гандантэгчинлэн хийд удалгүй шарын шашны эрдмийн гол уурхай болжээ. Тэгвэл Эрдэнэ зуу удаан хугацаагаар зөвхөн хурал мөргөлийн газар байж, нөлөө нь улам бүр өсөн нэмэгдэж буй Гандантэгчинлэн хийдтэй өрсөлдөж чадахаа болино ач холбогдол нь зөвхөн орон нутгийн шинжтэй болж хувирав. Энэ нь майдар эргэх зэрэг шашны гол гол ёслолын үеэр илэрч байлаа. Тухайлбал Позднеевийн мэдээлснээр 1877 оны Их Хүрээний Майдар эргэх ёслолд 30 мянга орчим, харин Эрдэнэ

³⁴ И. Я. Коростовец, От Чингис Хана до Советской Республики I. Ja. Korostovec, Париш 1930 (Улаанбаатар 2004), 74 дэх тал.

зуугийнхад зөвхөн арван мянган сүсэгтэн оролцжээ.³⁵ Нөлөөгөө алдсан Эрдэнэ зуу хийдэд XIX зууны хоёрдугаар хагасаас янз бүрийн сургууль (*dacan*) байгуулан өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх гэсэн VIII цорж Ишчүлтэмпунцагийн оролдлого хэт оройтсон байжээ.

Монголын ноёд Жавзандамбын төвд хойд дүрүүдэд улам таагүй хандах болов. Тэр дундаа Төвдийн татварын баян түшмэлийн хүүг VIII Жавзандамбаар³⁶ тодруулсан нь тэдний дургүйцлийг ихээхэн төрүүлжээ. Ёслолын ажиллагааны урилга заллагыг Төвдөд хүргэх байсан Засагт хан Цэрэндэндэв өвчнөөр шалтаг заан явсангүй. Үүнээс нь болж түүнийг Бээжин эрс буруушаан шүүмжиллээ. Монголын ноёд язгууртнуудын дунд хятадуудад дургүйцсэн үзэл санааны өөрчлөлт хүчтэй явагдаж байв. Монголын ноёд язгууртнууд 1863 онд Хэрлэн голын хөвөөнд Чингис хааны шүтээнийг байгууллаа.³⁷

Нөхцөл байдал ийм байх цаг үеэр VIII Жавзандамба 1875 онд Хүрээнд залран иржээ. Тэгтэл ч тун удалгүй шарын шашны энэ шинэ тэргүүн Чин улсын засаг захиргаанаас тавьсан шаардлагыг хүлээн авдаггүй хэдэр зөрүүд зантай болох нь мэдэгдэв. Жавзандамба Хүрээнээс явахдаа Хүрээн дэх Манжийн Амбанаас зөвшөөрөл авах ёстой байв. Тэрхүү Амбан түүнд 1887 онд Эрдэнэ зуу хийдэд, 1889 онд Амар баясгалант хийдэд тус тус морилох зөвшөөрлийг өгчээ. Харин Жавзандамба цаашдаа ийм заавар журам баримталъя гэж огтхон ч бодсонгүй. Тэр бээр зөвшөөрөл авалгүйгээр 1890 онд хоёр удаа Амарбаясгалант хийдэд, 1895 онд Эрдэнэ зууд морилжээ. Эрдэнэ зуу түүнийг ид шидийн хүчээр татаж байв. Өндөр гэгээн Занабазартай дахин төрлүүдийн холбоогоор холбогдсоноо тэр өмнөх дүрүүдээсээ илүүтэйгээр мэдэрч байжээ.

1905-1906 онуудад Эрдэнэ зуу хийд хэсэг хугацаанд олон улсын анхаарлын төвд оржээ. Далай лам Түвдээс зугтсан байлаа. Тэр Их Хүрээнд ирэв. Тэнд тэр удалгүй Жавзандамбатай ихээхэн санал зөрөлдөх болжээ. Далай ламд Жавзандамбын амьдралын хэв маяг “шарын шашны номлол”-оос хазайж буй мэт³⁸ санагдсан бол Далай ламд гүн хүндэтгэл үзүүлж, ихээхэн бэлэг сэлт барьсан нь Жавзандамбын сэтгэлд нийцсэнгүй. Тэгээд Жавзандамба хэсэг хугацаанд Эрдэнэ зуу руу³⁹ явахыг завдав. Гэвч явж чадаагүй ажээ. Далай лам 1906 онд Гадаад Монголоос буцах замдаа мөн Эрдэнэ зууд заларсан байна. Тэр тэнд монголчуудын аугаа их түүхийг хүндэтгэж байгаагаа илэрхийлсэн нь “Монголын ард түмний зүрх сэтгэлийг” гүн гүнзгий ойлгож байгаагийнх нь илрэл болов. Далай ламын Эрдэнэ зууд хийсэн айлчлал улс төрийн хувьд ч нөлөөтэй байжээ. Монголчуудын тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх эрмэлзэлд тэр шинэ чухал түлхэцийг өгөв. Эл эрмэлзэл дараагийнх нь жилүүдэд улам хүчтэй болов. Энэ нь эцэстээ 1911 онд Жавзандамбыг “Монгол улсын Богд хаан”-аар ёслол төгөлдөр өргөмжилж, тусгаар тогтнолоо зарлан тунхаглахад хүргэсэн билээ.

³⁵ А. Позднеев, Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии в связи с отношениями сего последнего к народу, С. Петербург 1887, 389 дэх тал.

³⁶ Х. Жамсран, Шашин төрийг хослон баригч Богд Живзундамба Хутагт хаан, *Монголчуудын сэргэн мандалтын эхэл*, Улаанбаатар 1992, 158-184; С. Идшинноров, Г. Цэрэндорж, Жавзундамба Агваанлувсанчойжиннямадан занванчугбалсамбуу, Үнэн, 1990.06.16.

³⁷ U. B. Barkmann, Bemerkungen zum mongolischen Nationalismus ein Versuch I, *Humboldt Journal zur Friedensforschung* 3(1992), 1(1993), 80-91 дэх тал.

³⁸ J. Snelling, *Buddhism in Russia*, Shaftesbury 1993, 125 дахь тал.

³⁹ И. Ломакина Великий беглец, Москва 2001.

Түүнийг тийнхүү хаан ширээнд өргөмжилсөн нь ихээхэн бэлгэдлийн утга учиртай хэрэг байв. Анхдугаар Жавзандамба Өндөр гэгээн Занабазар нь ноёрхогч байр сууринд байсан Чингисийн алтан ургийн төлөөлөгч Түшээт ханы хүү байсан бол Монгол улсын хаан түүнтэй урьд төрлүүдээрээ холбогдсон байлаа. Иймээс хаан ширээнд түүнийг өргөмжилснөөр Чингисийн алтан ургийнхны ноёрхох эрмэлзэл тодорхой хэлбэрээр дахин биелэлээ олсон хэрэг юм.⁴⁰ “Түүний зэрэгцээгээр Монгол улсын хааныг “Монгол улсын эзэн, шашин төрийг хослон барьсан Богд хаан”⁴¹ гэх болжээ. “Шашин төрийг хослон барьсан Богд хаан” хэмээх нэрийг монголчууд юун түрүүн Хубилай хаан, Пагва лам Лодойжалцан нарын байгуулсан хэлэлцээртэй холбон үздэг байв.

1921 оны Зөвлөлт маягийн эргэлтийн хэдэн жилийн дараа шинэ эрх баригчид Монголд улам бүр Зөвлөлтийн жишгийг баримталсан шашны бодлогыг хэрэгжүүлж эхлэв. Гэхдээ тэд эхлээд VIII Жавзандамбыг хэмжээт эрхт хаанаар үлдээхээр шийджээ. Иймээс “Ардын Засгийн газар” түүнтэй 1921 оны 11-р сарын 1-нд “Тангаргийн гэрээ” байгуулж хааны улс төрийн бүх эрх мэдлийг хэрэгсэхгүй болгожээ. Уг гэрээнд заахдаа: “Нэгдүгээр зүйл. Монгол улсын Богд хаан Жавзандамба хутагт, шарын шашны богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй, шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино.”⁴² гэжээ. Ийнхүү төр шашныг хослон барих зарчмыг хэрэгсэхээ больжээ. Чин улсын эзэн хааны монголчуудыг илүү сайн захирахын тулд баримталж байсан бодлогыг Зөвлөлтийнхон ингэж өөрийн эрхгүй хэрэгжүүлэх болсон юм. Богд хааныг 1924 онд нас барахад Засгийн газрын сонин *Ардын эрх*-эд гарсан нэгэн өгүүлэлд Монгол улсын тусгаар тогтнолын төлөө түүний байгуулсан гавьяаг үнэлсэн байлаа. Уг өгүүлэлд анхдугаар Өндөр гэгээн Занабазарыг ч дурссан байв. Харин зохиогчид хэзээ шинэ хойд дүрийг нь тодруулах асуудлыг авч үзээгүй байлаа.⁴³ Жавзандамбыг нас барснаас хэдхэн хоногийн дараа Засгийн газар Ардын Бүгд Найрамдах Улс байгуулснаа тунхаглан зарлав. Москва Жавзандамбын хойд дүрийг тодруулахыг хүсэхгүй байгааг Зөвлөлтийн зөвлөхүүд нь Монголын Засгийн газарт тодорхой ойлгуулжээ. Монголын шарын шашин тэргүүнгүй болов. Мяндагтнууд нь энэ орон зайг бөглөх чадваргүй байлаа. Зөвлөлтийнхон сүм хийд, улмаар шашныг устгах удаан хүсэн хүлээсэн мөч нь ирснийг ойлгов. Эрдэнэ зуу ч бас хоногоо хүлээж байлаа.

Эрдэнэ зуу 30-аад оны эхээр 500 лам, 60 орчим сүм дугантай байв. Сүүлийн жилүүдийн асар их дарамт шахалтын улмаас олон лам хар болжээ. Эхний баривчилгаа эхлэв. 1931 онд баривчлагдсан лам нарын дотор лам Д. Дамдиндорж (сүүлчийн Түшээт хан, 1922 онд цолноосоо татгалзаж лам болсон), Ширээт цорж хувилгаан Гончигжанцан нар байв. Хувилгаан Гончигжанцанг Жавзандамбын хойд дүрийг тодруулна гэсэн цуу тараасан, Банчин ламыг Монголд залж ирэхийг завдсан хэмээн буруутгажээ. Түүнд долоон жилийн хорих ял оноосон ч дараа жил нь ерөнхий сайд П. Гэндэн түүнийг цагаатгасан байна. Гэвч зөвлөлтийн тагнуулын албаны зөвлөхүүд барьцаа сулруулалгүй түүнийг 1934 онд мөн дээрх

⁴⁰ U. B. Barkmann, *Geschichte der Mongolei*, Bonn 1999, 97 дахь тал.

⁴¹ No. 66, Богд Жавзандамба Монгол Улсын хаанаар өргөмжлөгдөөд буулгасан зарлигаас. *Монгол ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, Баримт бичгийн эмхтгэл* (1900-1914), Улаанбаатар 1982, 126 дахь тал.

⁴² Ардын Засгийн газар ба Богд хоёрын хооронд байгуулсан тангаргийн гэрээ, *БНМАУ-ын үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл*, Улаанбаатар 1972, 39 дэх тал.

⁴³ Бэлбэсэрлийг улсын нийтээр үйлдмүй, *Ардын эрх*, 12 (1924), *Ардын эрх*, 1991.09.14.

шалтгаанаар баривчлан хорьжээ. Засгийн газраас 1936 онд Эрдэнэ зууд илгээсэн төлөөлөгч тэнд очоод хийдийн үйл ажиллагааг хяналтандаа авч, хийдийг төлөвлөгөөтэйгээр буулгахад бэлтгэв. Тагнуулын алба 1937 оны 9, 10-р сард Эрдэнэ зуугийн лам хуврагуудыг баривчлахад нийтдээ 200 болсон байна. Ширээт цорж хувилгаан Гончигжанцан, түүний дүү гавьж Ядамсүрэн нарыг “Ёнзон хамба Лувсанхаймчигийн хувьсгалын эсэргүү төв”-ийн гишүүн, орон нутаг дахь бүлгийнх нь толгойлогч хэмээн буруутгалаа. Шүүх яаралтай шийдвэр гарган тэдгээр 200 лам хуврагт нэгийг нь ч үлдээлгүй алах ял оногдуулжээ. Шүүхийн шийдвэрийг гармагц нь шууд гүйцэтгэдэг байв. Цаазлагдсан лам нарын дотор сүүлчийн Түшээт хан лам Дамдинжамц ч бас байжээ. Энэ баривчилгааны дараа хийдэд ердөө 64-хөн лам үлдсэн байлаа. Тэд 1938 оны 6-р сард сүм хийдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын төлөөлөгчид Эрдэнэ зуу хийдийг хаах “хүсэлт”-ийг уламжилсан байна. Ингээд хийдийн үнэт зүйлсийг бүртгэн хурааж авчээ. Барилгын бригадууд хийдийг дэс дараалан нурааж эхлэв. Ийнхүү “гаргаж авсан” барилгын материалыг өөр газар ашиглажээ.

Монгол дахь ЗСБНХУ-ын дипломат төлөөлөгч М. И. Голубчик 1938 оны 8-р сарын 2-нд Гадаад хэргийн ардын комиссарын орлогч Б. С. Стомоняковт: “7-р сарын 20-ны байдлаар Монголын 771 сүм хийдээс 615-ыг нь устгаж, хаагаад байна”⁴⁴ хэмээн бичжээ. Энэ мэдээ тэр үед хэвшил болоод байсан төлөвлөгөөгөө амжилттай биелүүлсэн тухай тайлан мэт сонсогдож байлаа. Монгол дахь Сталины итгэлтэй хүн маршал Х. Чойбалсанг 1943 онд Засгийн газар хоорондын хэлэлцээ хийхээр Москвад очиход Дээд Зөвлөлийн дарга М. И. Калинин үл хүндэтгэсэн байдлаар: “Та нар олон түмнийхээ сүшиг бишрэлийг үл хайхран лам нар сүм хийдээ хүчээр устгасан байна.”⁴⁵ хэмээн доогтой хэлж хилэгнэн угтжээ. Калинин шашны үйл ажиллагааг дахин сэргээхийг шаардав. Монголын төлөөлөгчид Монголд эрдэмтэн лам ч, ном судар ч байхгүй болсон тул тэгэх бараг боломжгүй хэмээн хариулсан байна. Түүний дараачаар Чойбалсан Эрдэнэ зууд очжээ. Түүнд эвдэрч сүйдсэн хийдийн дүр зураг л харагдав. Жижиг сүмүүдийн оронд овоолсон хог л байх бөгөөд барилгын бригадууд нэгэн том сүмийг нурааж байхтай тэр таарчээ. Засгийн газар Шинжлэх ухааны хүрээлэн (Шинжлэх ухааны академийн өмнө байсан)-д нураасан барилгын балгасанд үзлэг шалгалт хийх үүрэг өгөв. Балмагдмаар урам хугалсан дүн гарчээ. Эрдэнэ зуугийн муудсан хэрмийн дотор 21 байгууламж л үлдсэнээс зарим нь ердөө балгас л гэж хэлж болохоор болсон байв. Зөвхөн хийдийг анх байгуулагдаж байх үеийн хуучин гурван сүмийн байгууламж болон алтан суварга л бага ч болов янзаараа байлаа. Сайд нарын Зөвлөл 1944 оны 5-р сард “Монголын ард түмний түүх дурсгалын зүйл болох Хархорумыг Эрдэнэ зуугийн хамтаар хамгаалах ба засварлах тухай тогтоол”-ыг батлан гаргав. Түүний мөрөөр хийсэн сэргээн засварлах ажилд сүүлчийн Түшээт ханы охин Дэнсмаа ч бас оролцжээ. Түүнээс хэдэн жилийн хойно Зөвлөлтийн археологичид монгол археологичидтой хамт Эзэнт гүрний эртний нийслэл Хархорумын нутаг дэвсгэр дээр анхны томоохон малтлагыг хийж, Зөвлөлтийн экспедицийн дарга С.В. Киселев тэр үед хуучин Эрдэнэ зуу хийдийн сэргээн засварласан Лаврин (төвдөөр *hla-brang*) сүмд сууж байсныг түүхийн хошигнол биш гэх үү.

Эрдэнэ зуу хийд зөвхөн музей хэлбэрээр социализмын үеийг даван туулжээ. Байшин барилгынх нь байдал эмгэнэлтэй гэж хэлэхэд ч багадааар болсон байв.

⁴⁴ Ил товчоо 26(1995).

⁴⁵ С. Ичинноров, Н. Банзрагч, *Эрдэнэзуу хийд ба Түшээт хааны хошуу*, Улаанбаатар 1999, 77 дахь тал.

1989-1990 оны улс төрийн өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд Монголын ард түмэн эх орныхоо бүрэн бүтэн эзэн нь байх эрхээ эргүүлэн олж авлаа. Шарын шашин дахиад чөлөөтэй хөгжих боломжтой болов. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газар 1990 оны эхээр Эрдэнэ зуу, Амарбаясгалант хийдүүдэд дахиад хурал мөргөлийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн тогтоол гаргажээ. 1992 оны 1-р сарын 13-ны шинэ үндсэн хууль ч шашны эрхээ дахин эдлэх баталгааг бүрдүүлэв. Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд шашин чөлөөтэй шүтэх нөхцлийг бүрдүүлж, “1. Монгол Улсад төр шашнаа хүндэтгэж, шашин төрөө дээдэлнэ.”⁴⁶ хэмээн заажээ. (Энд “шашин” хэмээх үг ганц тоон дээр, биеийн хамаатуулах төлөөний хэлбэрээр байгаа нь монголчуудын уламжлалт шарын шашныг хэлсэн гэдэгт эргэлзэх зүйл үгүй болохыг харуулж байна.)

Шарын шашны уламжлалыг сэргээхэд 1990 оноос Энэтхэг улсын элчин сайдаар ажилласан Далай ламын багш байсан Бакула Ринбүүчий гол үүрэг гүйцэтгэжээ. Тэр бээр Бакула гэгээний 20 дахь, Найдан хувилгааны 16 дахь хойд дүрээр тодорсон хүн байлаа. Бакула Монгол улсад элчин сайд болсон нь бэлгэдлийн утга учиртай, түүхэн Бакула шарын шашныг дэлгэрүүлэхээр умардад морилсон хэрэг байжээ. Бакула нь Монгол улсад цорын ганц Буддын шашны дээд хувилгааны хойд дүр байсан юм.

1997 онд Монголд нийт 154 бүртгэлтэй сүм хийд байсан бөгөөд шарын шашны сүм хийдийн сүлжээ ийнхүү бий болсон нь тодорхой хугацаанаас эхлэн нийтээр хүлээн зөвшөөрсөн шарын шашны тэргүүний асуудлыг дэвшүүлэн тавилаа. Тиймээс “Монголын сүсэгтнүүдийн холбоо” Монголын шашны тэргүүн Жавзандамбыг дахин тодруулах асуудлыг авч хэлэлцжээ. 1991 онд Далай ламын IX Жавзандамбын хойд дүрээр батламжилсан Соном Дарге (1932 онд Лхаст төрсөн)-г 1999 онд Монголд морилон ирэхэд энэ хэлэлцүүлэг туйлдаа хүрэв.

IX Жавзандамба 1999 оны 8-р сарын 5-нд Эрдэнэ зууд морилсон нь урьдах дүрүүдтэй нь холбон авч үзвэл улс төрийн өргөн цар хүрээтэй үйл явдал байлаа. Нэгэн Буддистуудын чуулган Жавзандамбыг Эрдэнэ зууд залрах үеэр нь Монголын Буддистуудын тэргүүнээр томилжээ. “Ерөнхий чуулган”, тэрчлэн “Нэгдсэн буддист соёлын бодлогын газар”, “Гадаад бодлогын ерөнхий газар”, “Монголын Буддистуудын хэрэг эрхлэх газар” гэсэн бүтэц бүхий Гүйцэтгэх байгууллага нь Хар хоринд төвлөрсөн “Ажлын алба” байгуулагдсан тухай Ардчилсан Холбооны Засгийн газрын захиалгаар хийсэн бололтой нэгэн судалгаанд тэмдэглэсэн байдаг. Зарим монгол судлаачдын дүгнэснээр шашны энэхүү сүүдрийн кабинет цөллөгөнд буй Түвдийн Засгийн газрын бүтэцтэй төстэй байсан нь анхаарал татна. Монгол улс гадаад бодлогодоо Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрх ашгийг харгалзан үзсэнээр эцэстээ IX Жавзандамба Энэтхэг рүү буцахад хүрчээ. Хар хоринд гаргасан шийдвэр, түүний биелэлтийн талаар дахиад юу ч сонсогдсонгүй. Эрдэнэ зуу хийдийн бэлгэдлийн шинжтэй нөлөөг харгалзан эс үзвэл уг хийд Монголын шашны амьдралд эдүүгээг хүртэл төдийлөн идэвхтэй үүрэг гүйцэтгэсэнгүй.

Гэхдээ IX Жавзандамбын айлчлалыг даган өрнөсөн үйл явдлууд Эзэнт гүрний эртний нийслэл Хархорумд улс төр сонирхогч олон нийтийн анхаарлыг бүр ч ихээр хандуулжээ. Тэр ч байтугай Улсын Их Хурлын нэг комисс Парламент, Засгийн газрыг Хар хорин руу нүүлгэх асуудлыг авч үзсэн ажээ.

⁴⁶ Монгол Улсын Үндсэн хууль, Улаанбаатар 1992, 5 дахь тал.

Мөн Хархорумд хийж буй Герман-Монголын малтлагын ажил Хархорум, Эрдэнэ зуу хийдийн түүхийг сонирхсон олон нийтийн сонирхлыг нэмэгдүүлэв. Монголын тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойн баярын үеэр Хар хориноос онцгой санал санаачлагууд гарсан юм. Тэнд 2006 оны 8-р сарын 2-8-нд утга учир бэлгэдэлтэй дэлхийн монголчуудын чуулган чуулж, түүнд Буриад, Халимаг, Якут, Энэтхэг, Өвөр Монголоос төлөөлөгчид ирж оролцжээ. Чуулганд оролцогсод “Дэлхийн монгол туургатны чуулганы дүрэм”-ийг батлан гаргав.⁴⁷ 800 жилийн ойн баярын арга хэмжээнд ерөнхий сайд Ж. Коизумиг оролцохын өмнө Япон улс Хархоринд музей байгуулахад зориулан 297 сая иений буцалтгүй тусламж үзүүлэх болсноо мэдэгдэв.⁴⁸

Өдгөө Хархорум болон Эрдэнэ зуу, түүний уламжлал нь монголчуудын түүх, улс төрийн ухамсрын салшгүй хэсэг болжээ. Түүнийг Хятадын ч, Зөвлөлтийн ч ноёрхол өөрчилж чадаагүй, Монголын өмнөд хөршийн үндэсний болон геополитикийн ашиг сонирхол ч өөрчилж чадахгүй. Оросын монголч эрдэмтэн А. М. Позднеевийн 1896 онд бичсэн урьдын адил хүчин төгөлдөр хэвээр байна. Тэр бээр: “Тиймээс Эрдэнэ зууг дурсмагц л монгол хүний сэтгэлд эх орноо хайрлах хайр, өнгөрснөө дурсч бишрэн хүндэтгэх, тэрхүү гэгээн шүтээний өмнө өвдөг сөхрөн бахдах сэтгэл төрдөг” хэмээн бичсэн байдаг.⁴⁹

⁴⁷ Дэлхийн монголчууд Хархорумд чуулна, *Зууны мэдээ*, 2006.06.24.

⁴⁸ Японы тусламжаар “Хар хорум музей” байгуулна, *Ардын эрх*, 2006.07.19.

⁴⁹ А. М. Позднеев, *Монголия и Монголы*, т. I, С. Петербург 1896, 427 дахь тал.